

ХЯТАД ДАХЬ МОНГОЛ ҮНДЭСТНИЙ ГАРВАЛ, ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНТЭЙ ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙ, ГАДААД БОДЛОГЫН ЗАРИМ АСУУДАЛ

THE ORIGINS OF ETHNIC MONGOLIANS IN CHINA, ISSUES OF LEGAL AND FOREIGN POLICY REGARDING IMMIGRATION



Ж.БАЯРБААТАР

АСЕАН, Хятад судлалын төвийн Хяналтын зөвлөлийн гишүүн, судлаач

BAYARBAATAR J.

Supervisory board member and Researcher fellow at the ASEAN, China Studies Center

Товч агуулга: 2011 онд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Монголчуудаа олуулаа болцгооё, Монгол нутагтаа ирцгээ”¹ хэмээн уриалга гаргасан нь бүх дэлхийн монгол туургатанд хандсан түүхэн үйл явдал болов. Уг уриалгыг Монголоор овоглох хэн бүхэн дэмжин хүлээн авсан боловч практикт хэрэгжиж механизм, эрх зүйн зохицуулалтын талаар тодорхой шийдэлд хүрээгүй нь томоохон асуулт болон тавигдаж байна. Тухайн уриалгыг тунхаглах үеэр Хятадад байсан хятад судлаачийн хувиар тус улс дахь монгол үндэстэн үүнийг хэрхэн хүлээн авах, ямар хандлага гаргахыг ажиглан судалж асан билээ. Энэ талаар дурдахын ялдамд Хятад дахь монгол үндэстний үүсэл гарвал, тэдгээрийн өнөөгийн байдал, түүх соёлын хүчин зүйлс, тэр нь хоёр улсын харилцаа, цаашлаад манай улсын үндэсний ашиг сонирхолд хэрхэн нөлөөлж болохыг товч дурдахыг хичээсэн болно.

Abstract: President of Mongolia Ts.Elbegdorj's 2011 plea for “Mongolians to come together and return to their ethnic homeland” is a historical event for ethnic Mongolians across the globe. The President's call has been well received among all those with a Mongol identity. However, the ambiguous mechanism of implementation and unclear legal environment questions the President's call. The declaration was made during my stay in China allowing me to examine and survey how ethnic Mongolians in China received and reacted towards this call, which this paper will elaborate on. Furthermore, the article also attempts to provide the reader a short introduction on the origins of ethnic Mongolians in China, their current status, cultural and historical factors and its impact on the bilateral relations of our countries and its possible influence on Mongolia's national interests.

Түлхүүр үгс: Хятад дахь монголчууд, Өвөр Монгол, монгол үндэстэн, монгол хэл соёл, Ерөнхийлөгчийн уриалга, гадаад харилцаа, үндэсний аюулгүй байдал.

Key words: Ethnic Mongolians in China, Inner Mongolia, ethnic Mongolian, Mongolian language and culture, the President's plea, foreign relations, national security.

¹ Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний 100 жилийн ойн баярт зориулсан УИХ-ын хүндэтгэлийн чуулганд хэлсэн үг. 2011 оны 12-р сарын 28.

НЭГ. ХЯТАД ДАХЬ МОНГОЛЧУУДЫН ГАРВАЛ

Монгол үндэстэн угсаатан үүсэн буй болсон цагаасаа хойш өргөжин тэлж өргөн уудам нутаг дэвсгэрт тархан амьдарч ирсэн. Тэд түүхэндээ Ази, Европыг дамнасан Их Монгол Улсыг байгуулж явсан бөгөөд хятадын түүхэнд урьд өмнө байгаагүй олон үндэстнийг нэгтгэсэн Их Юань гүрнийг үүсгэжээ². Хубилай хаанаас Тогоонтөмөр хааныг хүртэл 100 гаруй жилийн хугацаанд монголчуудын өмнө зүгт хийсэн аян дайн, эзлэн авсан нутаг орноо үлдэн захирах шаардлагын дагуу олон тооны монгол үндэстэн Юань гүрний өнцөг булан бүрт суурьшин амьдрах болсон нь өнөөгийн хятад дахь монгол үндэстний үүсэл гарлыг зохируулжээ.

1368 онд өрнөсөн хятад тариачдын бослого Юань гүрний нэгдсэн захиргааг задалж, Тогоонтөмөр хаан уугуул нутагтаа шилжин суурьшив. Хаан эзнээ дагалдан буцаж эс чадсан монголчуудын тоо тухайн үед 400 мянгад хүрч байсны олонх нь язгууртан, цэргийн эрхтнүүд бөгөөд ихэвчлэн төв, баруун өмнө зүгт суурьшин байв. Энэ нь өнөөгийн Хөнань, Шаньдун, Юньнань, Гүйжоү, Сычуаний монголчуудын өвөг дээдэс болох юм.³

Монгол үндэстэн өдгөө Хятадын өөртөө засах зарим орон, муж хотуудад өргөнөөр тархан суурьшжээ. Эдгээрт Өвөр Монгол, Синьзян, Цинхай, Ляонин, Зилинь, Хэйлун Зян, Хөнань, Хөбэй, Шаньдун, Шаньсы, Ганьсу, Зянсу, Фузень, Гуандун, Хубэй, Хунань, Сычуань зэрэг мужууд орж байна. Түүх, улс төр, нийгмийн хүчин зүйлээс шалтгаалж эдгээр газар орны монгол үндэстнүүд хэл, соёл уламжлалаа харилцан адилгүй хадгалан иржээ. Зарим монголчууд хэл, соёлоо бүү хэл өөрсдийгөө “монгол үндэстэн” гэдгээ мэддэггүй нь сонирхолтой. Тогоонтөмөр хаанаас хойш хятад дахь монголчуудыг хүйс тэмтрэх, гадуурхан хавчих явдал 1960-аад оны Соёлын хувьсгалыг

хүртэл ямар нэгэн хэмжээгээр оршсоор ирсэн нь хятадын төв, өмнө зүгийн монголчууд угсаа гарвалаа бусдаас төдийгүй өөрөөсөө хүртэл нуух түгээмэл үзэгдлийн гол шалтгаан болсон. Урт удаан хугацаанд бүрэлдсэн түүхэн нөхцөл байдал, цаг уур, ахуй амьдралын хэвшлээс шалтгаалж эдгээр монголчуудын өдөр тутмын дадал, зүс царайнд хүртэл өөрчлөлт орж “хятаджсан” байдал илт ажиглагддаг. Зарим угсаатан судлаачдын нягт нарийн ажиглалтын дүнд зарим орны монголчуудын зан заншил, үлгэр домог, үг хэллэгээс тэдгээрийг монгол үндэстэн гэдгийг батлах сэжүүр тэмдэг илрэн гарах нь бий.

Харин хятадын хойд зүгийн монгол (өвөрмонгол)-чууд өөрсдийн унаган төрх, уламжлалт ёс заншил, хэл соёлоо өнөөдрийг хүртэл харьцангуй сайн хадгалан ирсэн нь цаг үеийн хүчин зүйл, тэдгээр нь тооны олноор уугуул нутагтаа аж төрөн суудаг байсан зэрэгтэй нягт уялдаатай. Түүхийн ээдрээ нугачаатай хүнд хэцүү замыг туулсан өвөр монголчууд монгол үндэстэн зонхилсон Өвөр Монголын өөртөө засах орныг байгуулсан нь Хятад дахь монгол нэрийгтэлтэй субъектуудын хамгийн том нь юм. Энэ талаарх түүхэн тэмдэглэлд: “1636 онд Зүүн Монголын 16 аймгийн ноёдын чуулган болж Манжийн хаан Абахайг Монголын хаанд өргөмжлөв. Ийнхүү Өвөр Монгол гэсэн шинэ нэр томьёо үүслээ. Халх ба Ойрд нь Манжийн харьяалалд ороогүй тул Гадаад Монгол, Ар Монгол гэсэн хэллэг үүнтэй зэрэгцэн буй болов”⁴ гэжээ.

1911 оны Чин Хайн хувьсгалын үр дүнд Монгол, Хятадыг 267 жил эрхшээсэн Чин гүрэн мөхлөө. Энэ нь монгол, хятад үндэстнүүд харийн дарлалаас чөлөөлөгдөн хувь заяандаа эзэн суух эрхийг адилхан олж авсан түүхэн үйл явдал байв. 1911 оны 12 дугаар сарын 29-нд монголчууд Жавзандамба хутагтыг хаан ширээнд залж, Монгол Улс байгуулагдан тусгаар

² 那仁高娃、李儿之斤。苏日娜、李儿之斤。苏和：“中国蒙古族系列丛书之一、蒙古三大部”，第2页

³ 那仁高娃、李儿之斤。苏日娜、李儿之斤。苏和：“中国蒙古族系列丛书之一、蒙古三大部”，第21页

⁴ Баабар. “Монголчууд: Нүүдэл, суудал”, Нэгдүгээр дэвтэр, 127 дугаар тал.



тогтносныг албан ёсоор тунхаглав. Халх Монгол тусгаар тогтнолоо зарласны дараа бусад монголчууд энэ шинэ улсад нэгдэн орох хөдөлгөөн Хянганаас Алтай, Цагаан хэрмээс Байгал далайн хоорондох өргөн уудам нутагт өрнөв. Энэ бол үе үеийн монголчуудын уугуул өргөн дэлгэр нутаг⁵. Гэвч тухайн үеийн олон улсын нөхцөл байдал, их гүрнүүдийн бодлогын учир Өвөр, Буриад, Халимаг, Урианхай монголчууд өнөөгийн Орос, Хятадын харьяанд үлдэх түүхэн нөхцөл бүрэлджээ. 1947 онд Өвөр Монголын Өөртөө Засах Орон албан ёсоор байгуулагдсанаар Хятад улс дахь хамгийн олон монгол үндэстэн

амьдардаг бүс нутгийн өнөөгийн хэлбэр баталгаажсан юм.

ӨМӨЗО-нд өнөөдрийн байдлаар 24 сая гаруй хүн амьдарч буйн 4 сая орчим нь монгол үндэстэн гэж албан эх сурвалжид тэмдэглэдэг⁶. Ихэнх судлаачид уг тоог зохиомлоор өсгөсөн хэмээн үздэг ч дэлхий дээр хамгийн олон монгол үндэстэн амьдардаг орон бол Хятад улс, тэр дотроо Өвөр Монгол гэдэгтэй үндсэндээ санал нийлдэг.

Өнөөдөр Хятадад монгол үндэстний нэрийгтгэл бүхий засаг захиргааны 12 нэгж байна. Үүнд:⁷

⁵ Баабар. “Монголчууд: Нүүдэл, суудал”, Нэгдүгээр дэвтэр, 248 дугаар тал.

⁶ <http://www.zh.wikipedia.org/wiki/%C4%DA%C3%C9%B9%C5#.E4.BA.BA.E5.8F.A3>

⁷ <http://www.baikе.baidu.com>

#	Засаг захиргааны нэгжийн нэрийгтгэл	Төв	Газар нутаг	Хүн ам
Өөртөө засах орон				
1	Өвөр Монголын Өөртөө Засах Орон	Хөх хот	1,2 сая км ²	Нийт 24,7 сая, үүнээс монгол үндэстэн 3,9 сая
Өөртөө засах жоу				
2	Цинхай мужийн Хайсы монгол үндэстний өөртөө засах жоу	Дэлхий хот	325,7 мянган км ²	Нийт 489,3 мянга, үүнээс монгол үндэстэн 24 мянга
3	СУӨЗО-ны Бор талын монгол үндэстний өөртөө засах жоу	Бор тал хот	27,0 мянган км ²	Нийт 424,3 мянга, үүнээс монгол үндэстэн 22,4 мянга
4	СУӨЗО-ны Баянголын монгол үндэстний өөртөө засах жоу	Курл хот	482,7 мянган км ²	Нийт 1,3 сая, үүнээс монгол үндэстэн 51,1 мянга
Өөртөө засах сиянь				
5	Ганьсу мужийн Сүбэй монгол үндэстний өөртөө засах сиянь	Сүбэй балгас	69,3 мянган	Нийт 13,1 мянга, үүнээс монгол үндэстэн 5 мянга
6	Хар мөрөн мужийн Дөрвөд монгол үндэстний өөртөө засах сиянь	Тайкан балгас	6 мянган км ²	Нийт 243,2 мянга, үүнээс монгол үндэстэн 42,8 мянга
7	Цинхай мужийн Хэнань монгол үндэстний өөртөө засах сиянь	Юу Ганнин балгас	6,9 мянган км ²	Нийт 44 мянга, үүнээс монгол үндэстэн 40,9 мянга
8	Зилинь мужийн Өвөр Горлос монгол үндэстний өөртөө засах сиянь	Өвөр Горлос балгас	6,9 мянган км ²	Нийт 567 мянга, үүнээс монгол үндэстэн 58 мянга
9	Хэйбэй мужийн Вэйчан монгол үндэстний өөртөө засах сиянь	Вэйчан балгас	9,2 мянган км ²	Нийт 520 мянга, үүнээс монгол үндэстэн 290 мянга

10	Ляонинь мужийн Фүсин монгол үндэстний өөртөө засах сиянь	Фүсинь балгас	6,2 мянган км ²	Нийт 730,6 мянга, үүнээс монгол үндэстэн 146,1 мянга
11	Ляонинь мужийн Харчин зүүн монгол үндэстний өөртөө засах сиянь	Дачэнзы балгас	2,2 мянган км ²	Нийт 433 мянга, үүнээс монгол үндэстэн 83 мянга
12	СУӨЗО-ны Ховог сайрын монгол үндэстний өөртөө засах сиянь	Ховог сайр балгас	31,7 мянган км ²	Нийт 57 мянга, үүнээс монгол үндэстэн 34.4 мянга

Дээр дурдсан засаг захиргааны нэгжүүд нь Хятадын засгийн газраас монгол үндэстний гарвал угсааг албан ёсоор хүлээн зөвшөөрч, монгол хэл, соёлыг хадгалан хөгжүүлэх, монгол үндэстэн нутгийн захиргааны байгууллагыг удирдах давуу "эрх"-ийг олгосон явдал хэмээн ойлгож болохоор байна.

ХОЁР. ХЯТАД ДАХЬ МОНГОЛЧУУДЫН ХЭЛ, СОЁЛ

Монгол хэл нь ӨМӨЗО-ны нийтэд хэрэглэх нэгдүгээр хэл хэмээн албан ёсоор тогтоогдсон ч өвөр монголчуудын дунд албан бусаар хятад хэлийг эн тэргүүнд тавих явдал газар авсан. Ажилд орох, албан тушаал ахих, гадаадад суралцах зэрэг тохиолдолд хятад хэлэнд сайн хүмүүсийг эхэлж сонгодог байдал нь өвөр монголчуудыг өөрийн эрхгүй хятад хэлийг сайн сурах, түүгээр ч зогсохгүй үр хүүхдүүддээ сургах үндсэн шалтгаан болжээ. Үүний улмаас тэд өөрийн үндэстний түүх соёл, зан заншил, үг хэл, үсэг бичгээ үл хүндэтгэхэд хүрдэг. Энэхүү үзэгдэл Өвөр Монголын хот, хөдөөд нийтлэг тохиолдож, эрчээ авсаар байна.⁸

Хэдийгээр монгол нэрийтгэлтэй субъектууд өөрсдийн үндэсний хэл, соёлоо хадгалах улс төр, эрх зүйн орчин бүрдсэн нь сайн талтай ч бодит амьдрал дээр монгол хэл, соёл өдрөөс өдөрт алдагдан хэлбэр төдий болж буй нь харамсалтай. Энэ нь аливаа үндэсний хэл, соёл хадгалагдан үлдэх үндсэн нөхцөл нь нийгмийн бодит хөрс бүрдсэн байх явдал буюу өдөр тутмын ахуй амьдралд зайлшгүй хэрэглэгдэх ёстойг харуулсан тод жишээ юм.

Хятад дахь монголчуудын дунд монгол соёл, уламжлалаа хамгийн сайн

хадгалсан гэх Шилийн гол аймгийн малчид малаа моторт тэргээр хариулах, бэлчээрийн газрыг хашаалснаас хойш уламжлалт уналга, ачлага, түүнийг дагасан мал ахуйн соёл үндсэндээ байхгүй болж байна. Тухайлбал морио унах нь цөөрснөөр эмээл, хазаар, ногт хийх, морь уралдуулах зэргээр зөвхөн морь эдлэх хэрэглэхээс үүдэн гарах бүхий л ахуй, ёс заншил байхгүй болох нь зүй ёсны үзэгдэл. Харамсалтай нь энэхүү нийтлэг үзэгдэл өмнөөс умард тийш нүүдэллэн дэлхийн монголчуудын гал голомт Монгол Улсын тал нутагт дэлгэрч эхэлсэн нь эмгэнэл юм.

Өвөр Монголын нутгаар аялан явбал мөнгөн аяга, ташуур, тулга, хонь зэрэг монгол соёлын онцлог бүхий олон хөшөө дурсгалыг харж болно. Энэ нь хэлбэр талаасаа монгол соёл, уламжлалаа дээдлэх мэт харагдаж буй ч агуулга талаас нь авч үзвэл өвөр монголчуудын өдөр тутмын амьдралд "морио ташуурдах, мөнгөн аяганд цай уух, тулганд гал түлэх" явдал алга болж, зөвхөн түүнийг дурсан санагалзах үүднээс хөшөө босгоход хүрснийг илтгэнэ.

Эндээс үзвэл, Хятад дахь монголчуудын гол төлөөлөл өвөр монголчуудын монгол соёл, уламжлал хэрэг дээрээ хэлбэр төдий бөгөөд ахуй амьдралаас тасарсан хийсвэр, зөвхөн соёл урлагийн салбарт амь голтой тэжээгдэн буйг харж болохоор байна. Сүүлийн жилүүдэд өвөр монголчуудын "санаачлагаар" монгол үндэстний соёлын илэрхийлэл болсон морин хуур, уртын дуу, хөөмий, монгол дээл зэргийг өвөр монголчууд зөвхөн өөртөө хамаатуулан нийт монгол туургатныг төлөөлөн дэлхийн өвд бүртгүүлж эхэлсэн нь хэлбэрдэлт хэр зэрэг өндрөө

⁸ "蒙古国研究" 杂志，内蒙古自治区的民族教育有关问题，内蒙古大学蒙古学院教授乌兰敖都，2014年



Хууль сахиулахуй

авч буйн бодит илэрхийлэл юм.

ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГО БА ХЯТАД ДАХЬ МОНГОЛЧУУД

Монгол Улсын гадаад бодлого бодитоор хэрэгжих тааламжтай нөхцөлүүдийн нэг нь хилийн чанад дахь монгол нэрийтгэлтэй субъектууд мөн. Энэ үүднээс авч үзвэл дэлхийн монгол туургатнууд өөрсдийгөө монгол үндэстэн гэдгээ гүнзгий ухамсарласан, монгол хэл, соёлоо хадгалан үлдсэн байх урьдач нөхцөлийг заавал шаардана.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд, “Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлалаа хадгалж, хамгаалж, хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн”⁹. “Монголын түүх, хэл, соёл, шашин, зан заншлыг хамгаалах, хөгжүүлэх, судлах ажлыг төр ивээлдээ авч, ном, сурах бичиг, кино урлагийн бүтээл туурвилыг онцгойлон урамшуулж, биет болон биет бус соёлын өвийг хамгаалан хөгжүүлнэ. Дэлхийн Монгол судлалын төвийг Улаанбаатарт байгуулж монголч эрдэмтдийг судалгааны ажлуудад татан оролцуулах, бусад оронд салбар байгуулах ажлыг зохион байгуулна”¹⁰ гэжээ.

Түүнчлэн шинээр батлагдсан Гадаад бодлогын үзэл баримтлалын Соёл, хүмүүнлэгийн гадаад харилцааны бодлогод “Соёл, хүмүүнлэгийн гадаад харилцааны бодлогын зорилго нь үндэсний соёл иргэншил, өвөрмөц өв уламжлалаа дэлхийн соёлын нийтлэг ололттой хослуулан хөгжүүлэх, . . . нийгэм, хүмүүнлэгийн салбарын шууд харилцаанд тус дөхөм үзүүлэх явдал мөн”¹¹ бөгөөд энэхүү зорилтыг “Бусад улс дахь монгол туургатнуудтай харилцаа хамтын ажиллагаагаа өргөжүүлж, хэл, соёл, уламжлалаа хадгалан хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх”¹² замаар хэрэгжүүлэхийг чухалчилжээ.

Эндээс үзвэл бусад улс оронд буй монгол үндэстнүүд Монгол Улсын гадаад бодлогын хэрэгжилтэд тодорхой дэмжлэг үзүүлэхүйц, тухайн улсын манай улстай харилцах харилцаанд идэвхтэй оролцогч байх нь бодит шаардлага хэмээн тодорхойлж болно. Харин тэдгээр монголчууд нь монгол хэл, соёлыг тээгч бөгөөд монгол үндэстэн гэдгээ гүнээ ухамсарласан байх нь хамгийн гол нөхцөл гэдгийг дахин дурдах нь зүйтэй.

Өнөөдрийн байдлаар Монгол Улс ба хятад дахь монголчуудын харилцаа хамгийн идэвхтэй байна. Учир нь Хятад, Монголын улс төр, нийгэм, эдийн засаг, урлаг, соёлын салбар дахь харилцаа, хамтын ажиллагаанд хятад дахь монгол нэрийтгэлтэй субъектуудын хамгийн том төлөөлөл ӨМӨЗО чухал байр суурь эзэлдэг. 1990-ээд онд сөргөлдөгч лагериудын нөлөөгөөр царцанги байдалд байсан хоёр талын харилцаа эргэн сэргэж, шинэ агуулгаар баяжих үйл явцад өвөр монголчууд зохих хувь нэмрээ оруулсныг мартаж үл болно. Ерөөс Хятадаас Монголд чиглэсэн аливаа бодлогын үндэслэл, хэрэгжилтэд хятад дахь монголчуудын нөлөөлөл ямар нэгэн хэмжээгээр байсан, цаашид ч байхыг анхаарах шаардлагатай.

Хоёр талын харилцаа эргэн сэргэсний дараа хятад дахь монголчуудын зүгээс Монгол Улсад зорчих, улмаар суурьших явдал улам бүр нэмэгдсээр байна. 2011 онд Монгол Улсын Ерөнхийлөгч “Монголчуудаа олуулаа болцгооё, Монгол нутагтаа ирцгээ”¹³ хэмээн уриалсан нь нийт монгол туургатны эцэг өвгөдийн гал голомтоо зорих урмыг бадрааж, зоригийг хөвчилсөн түүхэн үйл явдал байв. Харамсалтай нь уг бодлогыг бодит амьдрал дээр хэрэгжүүлэх зохицуулалтын механизмыг өнөөг хүртэл бүрдүүлж өгөөгүй байна. Уг уриалга гарсны дараах хятад дахь монголчуудын зүгээс Монгол Улсад шууд ирэх, тус улсын иргэн болох сонирхлоо илэрхийлсэн цөөнгүй хүн

⁹ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 1.1.6, 2011.

¹⁰ Мөн тэнд. 3.1.4.1, 2011.

¹¹ Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, 24, 2011.

¹² Мөн тэнд. 25.1, 2011.

¹³ Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний 100 жилийн ойн баярт зориулсан УИХ-ын хүндэтгэлийн чуулганд хэлсэн үг. 2011 оны 12-р сарын 28.

байсан боловч эрх зүйн тодорхой орчин, нийгмийн сэтгэлзүй бүрдээгүй байсан нь томоохон тээг болсон.

Ерөнхийлөгчийн уриалга амьдрал дээр хэрэгжихэд үүсч буй өөр нэг асуудал нь тухайн хүнийг монгол үндэстэн мөн гэдгийг хэрхэн тодорхойлох тухай юм. Тухайлбал монгол хэл, соёл мэдэхгүй, гаднах төрхөөрөө монгол хүнтэй огтын төсгүй хүн “би монгол үндэстэн, Ерөнхийлөгчийн уриалгыг сонсоод ирлээ, намайг Монгол Улсын иргэн болгож өг” хэмээн Хятад дахь манай улсын дипломат төлөөлөгчийн газарт хандсан тохиолдол нэг биш удаа давтагдсан. Тухайн хүнтэй уулзаж ярилцахад “өвөг дээдэс нь түүнийг монгол гэдгийг амнаас ам дамжуулан сануулж өсгөсөн, удам угсааг нь харуулах судар бичигтэй бөгөөд орон нутгийн судалгааны байгууллагаас

түүнийг нотолсон албан бичигтэй” хэмээн түүнийгээ үзүүлэх нь бий. Энэ тохиолдолд мэргэжлийн судлаачдын дүгнэлт шаардлагатай нь ойлгомжтой бөгөөд цаашид ч ийм практик дэлгэрэх хандлагатай байна. Нийгмийн сэтгэлзүй талаасаа хятадуудад таатай бус халх монголчуудын хувьд уг асуудлыг хэрхэн зөв шийдвэрлэх нь практик ач холбогдолтой.

Эцэст нь дүгнэхэд Монгол Улсын хамгийн том хөрөнгө оруулагч, эдийн засгийн гол хамтрагч, монгол туургатан хамгийн ихээр оршин суугч, стратегийн түнш Хятад улстай харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд тус улсын монгол үндэстний хүчин зүйлийг зайлшгүй харгалзах шаардлагатай бөгөөд уг хүчин зүйлийг хэрхэн тодорхойлж, ашиглах нь чухал асуудал мөн.

**Уншиж танилцан нийтлэхийг зөвшөөрсөн:
Сэтгүүлийн зөвлөлийн гишүүн, хууль зүйн доктор,
цагдаагийн хурандаа М.Эрдэнэбаяр**



МОНГОЛ
УЛСЫН
ХУУЛЬ
САХИУЛАХ
УРЬД
ХАМГАЙ
ХАМГАЙ
ХАМГАЙ